



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/1491

Номгон

Бог малыг мялзан өвчнөөс сэргийлэх
яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн “Бог малыг мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/315 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, дархлаажуулалт хийх хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж, чанартай зохион байгуулж үр дүнг 10 дугаар сарын 20-ны дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Дархлаажуулалт хийгдэж буй нутагт дэвсгэрт “Вакцины дархлаа” тогтох 28 хоног буюу 09 дүгээр сарын 12-оос 10 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байхад онцгой анхаарч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр), сум, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Мандал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624211229

Аймгийн Засаг даргын 2024 оны ... дүгээр
сарын -ны өдрийн А/... дүгээр
Захирамжийн нэгдүгээр хавсралт

**БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЯАРАЛТАЙ ДАРХЛААЖУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл, зорилго

Бог малын мялзан өвчин нь Монгол улсын хэмжээнд тархалт эрчимтэй өрнөж байгаатай холбоотой аймаг, орон нутгийн мал сүргийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

Дараах хүчин зүйлүүд нь энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, зорилго болсон. Үүнд:

1.1. Хил дамжин халдварладаг, мал, амьтны гоц халдварт Бог малын мялзан өвчний тохиолдол нь 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 3 аймгийн 5 сумын 5 голомтод бүртгэгдсэн;

1.2. Бог малын мялзангаар өвчилсөн мал мэдрэмтгий сүрэг дотор 2,2 сая толгой малд халдвар тархаах эрсдэлтэй гэж улсын хэмжээнд гараад байна.

1.3. Бог малын мялзан өвчинд мэдрэмтгий бүх бог малыг хамруулах вакцины хүрэлцээ улсын хэмжээнд хангалтгүй байна.

1.4. Тус аймгийн Өлзийт, Богд, Баянлиг сумдын 200,0 мянган хонин сүргийг яаралтай дархлаажуулалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хоёр. Ажиллах бүрэлдэхүүн, хугацаа

2.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс хойш 25 хоногийн хугацаанд шуурхай хэрэгжүүлэх;

2.2. Дархлаажуулалтын ажилд дайчлах хүн хүчний асуудлыг аймаг, сумдын Засаг дарга болон холбогдох бусад байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, богино хугацаанд үр дүнтэй, шуурхай зохион байгуулах;

2.3. Дархлаажуулалтын ажлыг орон нутгийн түвшинд хариуцан хэрэгжүүлэхэд сумдын мал эмнэлгийн тасаг, дүүрэг, хорооны Засаг дарга нарыг дайчлах мөн түүнд хяналт тавих ажилд аймгийн Мал эмнэлгийн газрын эмч, мэргэжилтэн, мал эмнэлгийн улсын байцаагч нарыг ажиллуулах;

2.4. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эсхүл дархлаажуулалтын багийг

ахалж яваа албан тушаалтан нь малчдын мал, тарилгын хашаа байрыг урьдчилан бэлтгүүлэх үүрэгтэй оролцох;

2.5. Тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавихаар томилогдсон ажлын хэсэгт вакцины заавар, зөвлөмжийг сайтар танилцуулах;

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.Аймгийн Мал эмнэлгийн газар, сумын Мал эмнэлгийн тасгаас тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавихаар томилогдсон ажлын хэсэгт вакцины заавар, зөвлөмжийг сайтар танилцуулах;

3.2.Хяналтын ажлын хэсэг нь вакцины хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн горим зөрчигдөж байгаа эсэх, тарилгын явцад технологийн алдаа гарч байгаа эсэх, орхигдсон айл өрх, мал байгаа эсэх, тарилгыг зураглалын дагуу гүйцэтгэж байгаа эсэх, тухайн суурийн малд эмнэлзүйн үзлэг хийж байгаа эсэхийг сайтар нягтлах;

3.3.Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цаг агаарын байдалтай холбогдуулан багийн гишүүдийн аюулгүй байдлыг сайтар хангасан байхаар зохион байгуулах;

3.4.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зураглалыг сум болон багийн түвшинд гаргаж, зураглалын дагуу тарилгын ажлыг гүйцэтгэх;

3.5.Тухайн вакцины хэрэглэх заавар болон хадгалах, тээвэрлэх нөхцлийн талаар мал эмнэлгийн тасгаас мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт тусгайлан танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулах;

3.6.Дархлаажуулалтын арга хэмжээнд хамрагдах өрх бүрийн гадна хашаа, саравчинд тарихаар зохион байгуулах, тарилгын нэг цэгт 1-ээс дээш өрхийн малыг цуглуулж тарихыг хатуу хориглох;

3.7.Дархлаажуулалт хийгдэж буй тухайн сум, дүүрэг, баг, хорооны эрсдэл бүхий нутагт байгаа өөр аймаг, сумаас оторлож яваа мэдрэмтгий малыг бүрэн тарилгад хамруулах ажлыг зохион байгуулах;

3.8.Дархлаажуулалтын арга хэмжээнд автомат тариур хэрэглэхээс зайлсхийж аль болох нэг удаагийн тариур ашиглах; Автомат тариур ашигласан тохиолдолд хий сорогдох, дутуу болон гадуур нь шахагдах зэрэг алдаанаас зайлсхийх, нэг өрхөд ашигласан тариурын зүүг дараагийн өрхөд ашиглахгүй байх, өрх бүрийн малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгах;

3.9.Вакциныг малчинд үлдээх, мал, амьтан эмчлэх итгэмжлэлгүй этгээд, улсын байцаагчийн дүгнэлтгүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч, дархлаажуулсны

дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.10. Дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгөх;

3.11. Вакциныг хэрэглэх зааварт заасан дархлаа бүрэн тогтох хугацаа (14 хоног) хүртэл отор нүүдэл, бог малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх анхааруулгыг малчдад өгөх;

3.12. Дархлаа бүрэн тогтох хүртэлх хугацаанд тухайн тарилга хийгдсэн өрхийн мэдрэмтгий малаас мал эмнэлгийн гэрчилгээ олгохгүй байх, мал эмнэлгийн гэрчилгээний хяналтыг сайжруулан ажиллах.

Дөрөв. Тайлагнах

4.1. Дархлаажуулсан малыг ялган тэмдэглэх (малчдаар будаг бэлдүүлэх, будуулах гэх мэтээр), өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийх, Мал эмнэлгийн нэгдсэн цахим систем-д мэдээллийг малчны хотноос заавал оруулах, тарилгын явцад хонины цэцгийн болон бусад халдварт өвчний шинж тэмдэгийн үзлэг, ажиглалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.2. Дархлаажуулалтын арга хэмжээнд малаа хамруулахаас татгалзсан болон бусад шалтгааны улмаас хамрагдаагүй өрх, малын судалгааг гарган аймгийн мал эмнэлгийн газарт яаралтай мэдэгдэж, нэгдсэн мэдээллийг зохих хяналтын байгууллагад хүргүүлж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцуулах;

4.3. Дархлаажуулалтын ажлыг дүгнэхдээ малын тооны статистик мэдээлэл болон дархлаажуулалтад хамрагдсан малын мэдээллийг тулган нягтлах, зөрүү гарсан тохиолдолд шалтгааныг тодруулж цахим системийн үр дүн оруулах хэсгийн тодруулга хэсэгт тэмдэглэх;

4.4. Аймгийн МЭГ-ын мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дархлаажуулалтын өдөр тутмын болон нөхцөл байдлын мэдээллийг тарилга эхэлсэн өдрөөс хойш цахимаар илгээсэн хүснэгтийн дагуу өдөр бүрийн 16.00 цагт багтаан Undarmaa@bkh.vet.gov.mn цахим хаягаар илгээх;

4.5. Отор нүүдлээр яваа малчдад нутаг сэлгэхдээ анхаарах асуудлаар тусгайлсан зөвлөмж өгөх, дархлаажуулалтад бүрэн хамруулах;

4.6. Тарилгын цуваа нэг бүрийн дүнг хянаж магадлах, малчдын тамгыг бүрэн даруулсан байх шаардлага тавих;

4.7. Дархлаажуулалтын тарилгын мэдээллийг хавсралт хүснэгтийн дагуу бөглөж тайланд хавсаргах;

4.8. Дархлаажуулалтын явцад гарсан зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллах;

4.9. Мал эмнэлэг, үржлийн нэгжийн эмч нь тарилгын материалыг тарилга дууссанаас 15 хоногийн дотор Мал эмнэлгийн тасагт ирүүлсэн байх, тарилгын гүйцэтгэлд Мал эмнэлгийн улсын байцаагч технологийн хяналт тавьж ажиллах, дархлаажуулалтын ажлын илтгэх хуудас (нэгдсэн тайлан)-ыг Adiyasuren@bkh.vet.gov.mn цахим хаягаар ирүүлэх зэргээр тайлагнаж ажиллах

Тав.Хариуцлага

5.1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар дархлаажуулалтад хамрагдаж буй малчин өрхийн үхэр сүргийг бүрэн хамруулаагүйгээс шалтгаалан өвчлөл гарсан тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

5.2. Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч дархлаажуулалтын явцын хяналт тавиагүй дүгнэлт гаргасан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.3. Заасан хугацаанд хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг дээд шатны байгууллагад тайлагнаагүй тохиолдолд хууль, журмын дагуу зохих хариуцлагыг тооцно.

-----oO-----

Аймгийн Засаг даргын 2024 оныдүгээр сарын ... –ны өдрийн А/.....-р Захирамжийн хоёрдугаар хавсралт

**"БОГ МАЛЫН МЯЛЗАН" ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ВАКЦИНЫ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХУВААРЬ**

Д/д	Сумын нэр	Хамрагдах малын тоо			Шаардагдах вакцин		Хүлээн авсан гарын үсэг	Он сар
		Бод	Бог	Нийт	Вакцин мл	Вакцин тун		
1	Өлзийт	-	90000	90000		90000		
2	Богд	-	55000	55000		55000		
3	Баянлиг	-	55000	55000		55000		
Нийт			200000	200000		200000		

-----oOo-----